



**БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН
БИЕИЙН ТАМИР, СПОРТ ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 08 сарын 21 өдөр

Дугаар A/48

Улаанбаатар хот

Тэмцээний зардал гаргах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, "Биеийн тамир, спортын тухай" хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.3 дахь заалт, 20 дүгээр зүйлийн 20.1.2 дахь заалт, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монголын мастеруудын биеийн тамир спортын 7 дугаар "Их наадам" 2023 оны 08 дугаар сарын 24-нөөс 27-ны өдрүүдэд Хөвсгөл аймагт зохион байгуулагдах тул дүүргийн мастеруудыг тэмцээнд оролцуулсугай.

2. Тэмцээний тээврийн зардалд 1,300,000 (Нэг сая гурван зуун мянган) төгрөгийг спортын тэмцээн, уралдааны зардлаас гаргахыг Нягтлан бодогч (П.Бат-Оюун)-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Спортын хэлтсийн дарга (Ю.Батсайхан)-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Д.ОТГОНСҮРЭН